

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ” ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2022/7/НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn Орхон аймаг 2022 он	Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 7035 9826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 7035 8505 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитор: Б.Байгал Утас: 99359854 Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
4.1 Байгууллагын үйл ажилагаа	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23
5.1 Шилэн дансны мэдээлэл	23
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	24
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	25
8. Аудитын илрүүлэлт	25
8.1 Залруулсан алдаа	25
8.2 Төлбөрийн акт	25
8.3 Албан шаардлага	25
8.4 Зөвлөмж	25
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДТС	Дулаан Түгээх Сүлжээ
ОНӨХК	Орон Нутгийн Өмчит Хувьцаа Компани
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.03.15 № 106
танай _____-ны № _____-г

ЭРДЭНЭТ УС, ДУЛААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ ОНӨХК-ИЙН ЗАХИРАЛ
Д.БҮҮВЭЙБААТАР ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дугаар тогтоолоор Айл өрхийн болон дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрөөс хариуцан

төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэхийг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан. Уг тогтоолын хүрээнд 2020 оны 12 дугаар сарын нэгнээс 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэл 2510 аж ахуй нэгжид 6,186.8 сая төгрөг, 33587 айл өрхөд 12,316.4 сая төгрөг нийт 18,678.5 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлж Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас нэхэмжлэн авсан байна. Тооцоо нийлсэн актыг тайлант оноор бус, 2022 оны 3 дугаар сарын 18-аар тасалбар болгон баталгаажуулсан байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлангийн үзүүлэлтэд хийгдсэн шинжилгээгээр Компанийн хувьд борлуулалттай холбоотой авлага цуглуулалт сайжирч үр дүнгээ өгч байгаа ч нийт дансны авлагын эргэц өмнөх он (эргэц 190 хоног байсан)-оос 33 хоногоор удааширч 223 хоног болсон байна. Үүнд усны алдагдлаас үүссэн авлага, бусад байгууллагатай холбоотой авлага өссөн нь их нөлөөлжээ.

Авлагын эргэц удааширч, авлагын үлдэгдэл ихсэж байгаа нь компанийн төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж, санхүүгийн тогтвортой байдал муудах сөрөг үр нөлөөг бий болгох тул авлагын удирдлагын оновчтой бодлого хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй юм.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бараа материалын дансны үлдэгдэлд энэ онд орлого болон зарлага гараагүй 163.5 сая төгрөгийн 334 нэр төрлийн бараа материал байна.

Эргэлтийн хөрөнгөнд өгсөн тайлбараар олон жил болсон ашиглагдахгүй материалын үлдэгдэл, зарим нэг хэрэглэх боломжтой хөрөнгүүд хамтдаа бүртгэлд тусгагдсан байна. Дүгнэж үзэхэд эргэлтийн хөрөнгийн нөөцийг тооцоо судалгаагүй, хэрэгцээ шаардлагат тулгуурлаагүй, хяналтгүй, техник технологийн хөгжил дэвшил өөрчлөлтийг тооцоогүйгээр худалдан авч нөөц үүсгэсэн байна. Зарим эргэлтийн хөрөнгийг тухайн байгууллагын жил бүр төлөвлөөгүй орлого олох, орлогын төлөвлөгөө давах, зардал буурах зэрэгтэй уялдуулан бага багаар актлан устгаж зардалд бичдэг байна. Энэ нь олсон орлогыг үргүй зарцуулах, алдагдалд нөлөөлөх эрсдэл үүсч болзошгүй байна. Эргэлтийн хөрөнгийн 163.5 сая төгрөгийн хөдөлгөөнгүй үлдэгдэл болон хөдлөх үндсэн хөрөнгийн үлдэгдэлд санхүүгийн тайлангийн аудитаар үр дүн, үр ашиг, учир шалтгааныг тодруулах боломжгүй гэж үзэн тусгайлсан аудитаар дүгнэлт гаргах нь зүйтэй гэж үзлээ.

Бусад асуудал

Санхүүгийн байдлын тайлан, тодруулга тайланд татварын авлага 4.3 сая төгрөг, татварын өр 59.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй тусгагдсан. Татварын цахим системээс авсан татварын тодорхойлолтоор татварын авлага 48.4 сая төгрөг, татварын өр 158.3 сая төгрөг байна. Дээрх зөрүүгийн талаарх тайлбарт Булган аймгийн татварын хэлтсээс орлого болоогүй усанд ус ашигласны төлбөр нөхөн акт тавьсантай холбоотой шүүхээр өмгөөлөгч хөлслөн маргаан үүсгэсэн 179.9 сая төгрөг байна. Мөн ААНОАТ-ийн илүү төлөлт санхүүгийн тайланд 1.9 сая төгрөг, тодорхойлолтоор 2.6 сая төгрөг, зөрүү 0.7 сая төгрөг, Суутгагчийн хувь хүнд олгосон татвар санхүүгийн тайланд 1.7 сая төгрөг, тодорхойлолтоор 2.0 сая төгрөг зөрүү нь 0.3 сая төгрөг байна. Татварын тодорхойлолтод санхүүгийн тайланд үлдэгдлээр тусгагдаагүй зам ашигласны төлбөр 0.02 сая төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн 21.6 сая төгрөгийн илүү төлөлт байна. Дээрх татварын үлдэгдлийн талаар хангалттай зохистой нотлох баримт бүрдүүлэх цаг хугацаа хязгаартай байгаа тул санхүүгийн тайланд тусгагдсан үлдэгдэлд дүгнэлт олгох боломжгүй гэж үзсэн. Тус байгууллага татварын өр, авлагын үлдэгдлийг татварын цахим системийн тодорхойлолтой тулган баталгаажуулж байх шаардлагатай байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 бүлэг, 21 зорилт, 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлийг дээд шатны захирагч 98 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх

талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	388,700,010.87	1,059,656,924.09
1.1.02	Дансны авлага	10,149,243,462.49	15,126,332,973.53
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	15,789,656.72	5,173,706.40
1.1.04	Бусад авлага	4,328,620.06	2,489,727.78
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	1,976,276,222.73	570,323,078.32
1.1.06	Бараа материал	598,487,593.80	666,946,949.49
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	13,132,825,566.67	17,430,923,359.61
1.2.01	Үндсэн хөрөнгө	36,345,699,742.35	38,852,858,668.77
1.2.02	Биет бус хөрөнгө	157,316,108.62	136,404,386.62
1.2.03	Биологийн хөрөнгө	-	-
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.05	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.07	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	5,402,279,623.69	5,067,050,388.05
1.2.09	Газар / Биет бус хөрөнгө - Бусад /	2,465,395,000.00	2,465,395,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	44,370,690,474.66	46,521,708,443.44
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	57,503,516,041.33	63,952,631,803.05
2.1.1.01	Дансны өглөг	9,868,572,749.04	12,596,540,802.77
2.1.1.02	Цалингийн өглөг	-	-
2.1.1.03	Татварын өр	4,305,476.61	59,470,727.43
2.1.1.04	НДШ - ийн өглөг	-	-
2.1.1.05	Банкны богино хугацаат зээл	-	-
2.1.1.06	Хүүгийн өглөг	-	-
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	487,186,737.69	432,699,527.04
2.1.1.09	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	36,744,455.62	38,806,847.94
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	10,396,809,418.96	13,127,517,905.18
2.1.2.01	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.05	Хойшлогдсон орлого	5,402,279,623.69	5,067,050,388.05
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	5,402,279,623.69	5,067,050,388.05
2.2	Өр төлбөрийн нийт дүн	15,799,089,042.65	18,194,568,293.23
2.3.01	Өмч: - төрийн	5,231,568,753.18	5,231,568,753.18
2.3.02	Хувийн өмч	-	-
2.3.03	Хувьцаат	-	-
2.3.04	Халаасны хувьцаа	-	-
2.3.05	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,588,875,182.68	2,586,709,828.68
2.3.07	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	39,250,136,404.16	43,302,195,875.79
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(5,366,153,341.34)	(5,362,410,947.83)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	1,577,039.51
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(5,366,153,341.34)	(5,363,987,987.34)
2.3.11	Эздийн өмчийн дүн	41,704,426,998.68	45,758,063,509.82
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	57,503,516,041.33	63,952,631,803.05

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	17,995,893,360.00	20,725,136,039.51
02	Борлуулалтын өртөг	11,082,566,644.60	12,714,363,973.51
03	Нийт ашиг(алдагдал)	6,913,326,715.40	8,010,772,066.00
04	Түрээсийн орлого	-	-
05	Хүүгийн орлого	-	-
06	Ногдол ашгийн орлого	-	-
07	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
08	Бусад орлого	166,329,800.00	98,686,200.00
08.1	Орлогын дүн	166,329,800.00	98,686,200.00
09	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	7,772,099,594.28	8,106,916,693.19
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
12.1	Зардлын дүн	7,772,099,594.28	8,106,916,693.19
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(24,625,713.66)	(1,288,106.26)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	186,326,551.34	1,105,022.45
17.1	Олз, гарзын дүн	161,700,837.68	(183,083.81)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(530,742,241.20)	2,358,489.00
19	Орлогын татварын зардал	1,367,865.17	781,449.49
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(532,110,106.37)	1,577,039.51
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(532,110,106.37)	1,577,039.51
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

		/төгрөгөөр/				
Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн	
2019 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	5,231,568,753.18	2,589,755,958.06	37,282,875,393.16	(4,834,924,010.35)	40,269,276,094.05	
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	
Залруулсан үлдэгдэл	5,231,568,753.18	2,589,755,958.06	37,282,875,393.16	(4,834,924,010.35)	40,269,276,094.05	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(532,110,106.37)	(532,110,106.37)	
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	1,967,261,011.00	-	1,967,261,011.00	
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(880,775.38)	-	880,775.38	-	
2020 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	5,231,568,753.18	2,588,875,182.68	39,250,136,404.16	(5,366,153,341.34)	41,704,426,998.68	
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	
Залруулсан үлдэгдэл	5,231,568,753.18	2,588,875,182.68	39,250,136,404.16	(5,366,153,341.34)	41,704,426,998.68	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,577,039.51	1,577,039.51	
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	4,052,059,471.63	-	4,052,059,471.63	
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(2,165,354.00)	-	2,165,354.00	-	
2021 оны 12 сарын 31-р үлдэгдэл	5,231,568,753.18	2,586,709,828.68	43,302,195,875.79	(5,362,410,947.83)	45,758,063,509.82	

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,234,315,012.74	22,325,004,650.47
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	18,676,772,869.92	21,903,528,039.52
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,094,429,388.00	300,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	463,112,754.82	121,476,610.95
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	20,251,544,875.41	21,505,515,902.25
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,314,131,885.22	3,301,607,931.88
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	999,000,000.00	964,200,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,212,091,550.90	1,128,040,086.78
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	700,174,540.82	362,923,362.02
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	205,430,900.00	96,000,000.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	760,692,009.85	842,756,548.66
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	2,199,280.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	13,060,023,988.62	14,807,788,692.91
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(17,229,862.67)	819,488,748.22
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	-	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8	Бусад	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	307,651,576.00	148,531,835.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	307,651,576.00	148,531,835.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(307,651,576.00)	(148,531,835.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(324,881,438.67)	670,956,913.22
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	713,581,449.54	388,700,010.87
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	388,700,010.87	1,059,656,924.09

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			Биелэлт (Хувиар)
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
1. Ажил үйлчилгээ, бүтээгдэхүүн буюу техникийн үзүүлэлт							
1.1	Цахилгаан эрчим хүчээр хангах хэрэглэгчид	Айл өрх ААНБ	7,319 580	8,175 597	8,403 633	228 36	102.7 106
1.2	Дулаанаар хангах хэрэглэгчид	Айл өрх ААНБ	13,007 1,232	13,102 1,232	14,130 1,318	1,028 86	107.8 107
1.3	Цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах үйлчилгээ үзүүлэх хэрэглэгчид	Айл өрх ААНБ	12,394 1,384	13,319 1,380	14,156 1,474	837 94	106.2 106.8
1.4	Ус түгээх байр	Ширхэг	80	80	84	4	105
1.5	Ажиллагсад	Мян.төг	323	310	311	1	100.3
1.6	Дундаж цалин	Мян.төг	993,891.7	1,015,707.0	1,037,037.7	21,330.0	102.1
2. Орлого, зардал, ашгийн буюу эдийн засгийн үзүүлэлт							
2.1	Нийт орлого	Мян.төг	18,370,304.9	20,295,738.0	20,858,397.5	562,659.5	102.8
2.1.1	Цахилгаан	Мян.төг	5,157,963.8	5,304,122.6	6,175,494.6	871,372.0	116.4
2.1.2	Дулаан	Мян.төг	7,035,686.3	7,292,840.4	7,449,134.9	156,294.5	102.1
2.1.3	Цэвэр ус хангамж	Мян.төг	2,841,032.0	3,876,140.0	3,504,257.6	(371,882.4)	90.4
2.1.4	Ариутгах татуурга	Мян.төг	1,983,409.8	2,796,380.0	2,522,442.7	(273,937.3)	90.2
2.1.5	Цахилгаан шат	Мян.төг	115,681.5	115,000.0	115,265.8	265.8	100.2
2.1.6	ӨЗҮҮ хангамж	Мян.төг	753,613.3	765,562.1	843,934.7	78,372.6	110.2
2.1.7	Тоолуурын хэсэг	Мян.төг	56,909.4	47,692.9	29,203.9	(18,489.0)	61.2
2.1.8	Бусад	Мян.төг	426,008.8	98,000.0	218,663.3	120,663.3	223.1
2.2	Нийт зардал	Мян.төг	18,902,415.0	21,011,545.0	20,856,820.5	(154,724.5)	99.3
2.2.1	Үндсэн ба нэмэгдэл цалин	Мян.төг	3,852,324.3	3,778,430.1	3,870,225.0	91,794.9	102.4
2.2.2	Ажил олгогчоос төлөх НДШ	Мян.төг	524,355.5	515,327.0	545,819.9	30,492.9	105.9
2.2.3	Цахилгаан	Мян.төг	737,881.6	728,426.0	741,237.7	12,811.7	101.8
2.2.4	Дулаан	Мян.төг	20,878.3	20,582.8	20,413.6	(169.2)	99.2
2.2.5	Ус	Мян.төг	29,249.2	19,049.6	34,175.3	15,125.7	179.4
2.2.6	Урсгал засвар, сэлбэг	Мян.төг	269,698.2	277,155.3	283,459.2	6,303.9	102.2
2.2.7	Түлш шатахуун	Мян.төг	131,306.4	126,914.6	132,206.4	5,291.8	104.2
2.2.8	Албан томилолт	Мян.төг	2,778.3	5,628.0	1,623.3	(4,004.7)	28.8
2.2.9	Бичиг хэрэг	Мян.төг	17,884.0	20,345.6	18,123.5	(2,222.1)	89.0
2.2.10	Холбоо	Мян.төг	25,931.2	30,375.6	25,968.5	(4,407.1)	85.5
2.2.11	Хөдөлмөр хамгаалал	Мян.төг	135,905.4	163,921.0	168,761.2	4,840.2	102.9
2.2.12	Элэгдэл	Мян.төг	1,663,114.3	1,722,166.2	1,806,691.0	84,524.8	104.9
2.2.13	Зар сурталчилгаа	Мян.төг	2,059.1	4,000.0	4,325.9	325.9	108.1
2.2.14	Нийгмийн халамж	Мян.төг	140,523.4	157,390.0	129,506.8	(27,883.2)	82.2
2.2.15	ТЗЭ-ийн зохицуулалтын хөлс	Мян.төг	34,165.0	41,525.2	81,725.3	40,200.1	196.8
2.2.16	Татвар, даатгалын зардал	Мян.төг	30,583.6	33,545.1	32,990.7	(554.4)	98.3
2.2.17	Гаднын үйлчилгээний хөлс	Мян.төг	31,741.9	36,979.6	36,995.7	16.1	100.0
2.2.18	Бусад үндсэн үйл ажиллагаа	Мян.төг	121,720.0	59,614.0	172,667.7	113,053.7	289.6
2.2.19	Худалдан авсан эрчим хүч	Мян.төг	11,082,566.6	11,678,036.4	12,714,364.0	1,036,327.6	108.9
2.2.20	Үйл ажиллагааны бус зардал	Мян.төг	47,748.7	25,427.9	35,539.8	10,111.9	139.7
2.2.21	Орлого болоогүй усны төлбөр	Мян.төг	-	1,566,705.0	-	(1,566,705.0)	(100.0)
2.3	Ашиг, алдагдал	Мян.төг	(532,110.1)	(715,807.0)	1,577.0	717,384.0	(0.2)

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК -ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад “Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-ийн холбоотой цалин хөлс, бараа материал, худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дүгээр сарын 03-аас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-ийн ахлах аудитор Л.Баасандорж аудитор З.Баттуяа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Бямбадорж, захирал Б.Байгал, захиалагч талаас Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер, Б.Эрдэнэ, газрын дарга тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

“Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК -ийн 2021 оны санхүүгийн тайланг “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-д 2022 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн 96 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө дунд зэрэг байна гэж үзсэн.

Дотоод хяналт, шалгалтын хэлтсийн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байсныг 9-р сараас татан буулгаж дотоод хяналт, шалгалт хариуцсан 1 ажилтан болгож өөрчилсөн байна.

Дотоод хяналт, шалгалтын хэлтэс эхний 9 сард санхүү эдийн засгийн чиглэлээр 10 ажил, мэргэжлийн хяналтын шалгах хуудасны чиглэлээр 10 ажил, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн чиглэлээр 7, алба хэлтсийн үйл ажиллагааны чиглэлээр 9 ажил хийхээр төлөвлөсөн ба гүйцэтгэл 58%-тай байна.

2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр тус компанийн дотоод хяналт шалгалтын гүйцэтгэх ажлын төлөвлөгөө шинэчлэн батлагдсан байна. Уг төлөвлөгөөгөөр санхүү эдийн засгийн чиглэлээр 5 ажил, мэргэжлийн хяналтын шалгах хуудасны чиглэлээр 10 ажил, батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн чиглэлээр 4 ажил, алба хэлтсийн үйл ажиллагааны чиглэлээр 5 ажил хийхээр төлөвлөжээ. Эдгээрээс авлигын эсрэг үйл ажиллагаа, алдагдал бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа, стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, техникийн нөхцөл олгох үйл ажиллагаа зэрэгт чиглэсэн дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа зохион байгуулагдаагүй, гүйцэтгэл 82.6% байна. Үүнээс санхүү эдийн засгийн чиглэлээр хийгдсэн дотоод хяналт шалгалтаар худалдан авах ажиллагааны биелэлтийг 80.7%, шилэн дансны хэрэгжилтийг 93% гэж үнэлэн, тооллогын үйл ажиллагаатай холбоотой зөвлөмжийг эд хариуцагч нарт хүргүүлжээ.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн ТУЗ-ын хурлын 2021 оны 1 дүгээр сарын 12-ний өдрийн 56 дугаар тогтоолоор батлуулан мөрдөж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Эрдэнэт ус ДТС” ОНӨХК нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан бизнес төлөвлөгөө дэх орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан бизнес төлөвлөгөөний орлого 20,195.7 сая төгрөгийн 2 хувиар буюу 403.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 282.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Эрдэнэт ус ДТС” ОНӨХК-ийн эрхэм зорилго нь “Эрчим хүч, ус хангамжийн цогц бүтэцтэй, орчин үеийн технологийг нэвтрүүлсэн салбарын тэргүүний байгууллага болоход оршино. Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд үндсэн үйл ажиллагааг дулаан түгээх, туслах үйл ажиллагааг халуун, хүйтэн усаар хангах, барилга угсралтын ажил, цахилгаан угсралт, цахилгаан түгээх, лифт, эскалатор, зорчигчийн ган татлагат болон чирэх замын угсралт, бохир ус цуглуулах, цэвэршүүлэх, ариутгах үйл ажиллагаа, халуун хүйтэн усны тоолуур засвар үйлчилгээ, усны тоолуур шалгах, суурилуулах гэж тодорхойлсон бөгөөд эдгээр тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Хүн ам, байгууллага, аж ахуйн нэгжид стандартын шаардлага хангасан цэвэр усыг тасралтгүй түгээх, бохир усыг зохих стандарт шаардлагын дагуу зайлуулах;
- Бохирдсон усыг зохих стандарт шаардлагын дагуу зайлуулах;
- Хэрэглэгчийн хэрэглээний цэвэр усны алдагдлыг бууруулах, цэвэр усанд стандартын дагуу лабораторийн шинжилгээг хийх;
- Хэрэглэгчдэд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах;

- Орон сууцны барилга, байгууламжийн цэвэр бохир ус, цахилгаан, дулааны шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг гэрээний дагуу хийх;
- Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулаг, дагалдах ажил үйлчилгээ;
- Даралттай шугам хоолой, ЦТП-ны засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ;
- Лифт, эскалатор, зорчигчийн ган татлагат болон чирэх замын угсралтын ажил, засвар техникийн үйлчилгээ хийх;
- Хэрэглэгчдэд цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах;
- Уст цэг, ус түгээх байрны ашиглалт, засвар үйлчилгээ;
- Нийтийн эзэмшлийн барилга байгууламж, шугам сүлжээ, техник, тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ, технологийн шинэчлэлт хийх, түүнийг зориулалтын дагуу ашиглах;
- Жаргалант, Дэнж багийн хэсгийн усан хангамжийн барилга, цэвэрлэх байгууламж, технологийн тоног төхөөрөмж шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ;
- Үндсэн үйл ажиллагаанаас гадна хуулиар хориглоогүй бусад бизнесийн үйл ажиллагаа;

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд тус компани орон нутгийн өмчит хувьцаат компанийн статустай байна. Өмчийг 100% орон нутаг буюу Орхон аймаг эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-ийг Орхон аймгийн ИТХ-ийн тэргүүлэгчдийн 2003 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд *“Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар ИТХ дараах бүрэн эрхтэй: ... 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих;...”* гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 18 дугаар зүйлийн 18.1.3.н, 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.7 зэрэг хуулийн заалтуудыг тус тус үндэслэн Орхон аймгийн ИТХ-ын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 47 дугаар тогтоолоор томилсон байгаа нь холбогдох хууль эрх зүйн актуудад нийцэж байна.

“Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг ТУЗ-ын хурлын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 48 дугаар тогтоолоор улирал бүр 0.2 сая төгрөг, жилд 0.8 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д *“...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна”* гэсэн заалттай нийцэж байна. Түүнчлэн 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн ТУЗ-ын хурлын 06 дугаар тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг улирал бүр 0.25 сая төгрөг, жилд 1.0 сая төгрөгөөр тогтоон 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлжээ.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон

өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд хийгдсэн арга хэмжээний талаарх хангалттай бөгөөд зохистой нотолгоо, мэдээллээр биднийг хангаагүй болно.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтэц дэх дотоод хяналт, шалгалтын хэлтсийг татан буулган өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 2-оор бууруулсан. Мөн ажлын ачааллыг харгалзан үзэж 2021 онд өргөх насосын операторчин, лифтний механик, ХАБЭА-н инженер, касс, УХА инженер, дулаан хуваарилах төвийн машинист зэрэг 6 орон тоог бүтэн жилээр, захиргаа хүний нөөцийн хэлтсийн даргын орон тоог 2 сараар хэмнэж, нийт 52.4 сая төгрөгийг цалингийн зардлаас, 7.1 сая төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас тус тус хэмнэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль
- Татварын тухай багц хууль,
- Нийгмийн даатгалын тухай багц хууль
- Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- НББ-ийн бодлогын баримт бичиг

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу 2021 оны санхүүгийн тайлангууд бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	2020.12.31		2021.12.31		
	Б	1	2	Өөрчлөлт	
				Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгө		388.7	1,059.7	671.0	172.6%
Бусад санхүүгийн хөрөнгө		1,976.3	570.3	(1,406.0)	-71.1%
Авлага		10,169.4	15,134.0	4,964.6	-60.7%
Урьдчилгаа		-	-	-	-
Бараа материал		598.5	666.9	68.5	11.4%
Үндсэн хөрөнгө		41,748.0	43,919.9	2,171.9	0.7%
Биет бус хөрөнгө		2,622.7	2,601.8	(20.9)	-13.3%
Нийт хөрөнгийн дүн		57,503.5	63,952.6	6,449.1	11.2%
Өр төлбөрийн дүн		15,799.1	18,194.6	2,395.5	15.2%
Богино хугацаат өглөг		10,396.8	13,127.5	2,731.7	26.3%
Урт хугацаат өглөг		5,402.3	5,067.1	(335.2)	-6.2%
Эздийн өмч		41,704.4	45,758.1	4,054.6	9.7%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		57,503.5	63,952.6	6,449.1	11.2%

Тус компани нь касс болон 5 арилжааны банканд харилцах данстай.

Касс нь орон сууц, аж ахуйн нэгжийн орлогын болон компанийн аж ахуйн гэсэн 2 төрөлтэй. Тайлант хугацааны эхэн болон эцэст эдгээр данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна. Тайлант онд касст Голомт дахь харилцах данснаас 15.6 сая төгрөг татан авч 15.5 сая төгрөгийг ахмадын баяр, өндөр настанд хүндэтгэл үзүүлэх, нийтийн аж ахуйн үйлчилгээний

баяр, эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулсан арга хэмжээ, шагнал урамшуулалд, 0.1 сая төгрөгийг бусад зардалд зарцуулсан байна.

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 1,059.6 сая төгрөг байна. Тус компани нь Голомт, ХХБ, Төрийн банк, Капитрон, ХААН банканд харилцах данстай бөгөөд Голомт банкны харилцах дансны үлдэгдэл 56.4 сая төгрөг, ХХБ-ны харилцах дансны үлдэгдэл 526.9 сая төгрөг, Төрийн банкны харилцах дансны үлдэгдэл 471.0 сая төгрөг, Капитрон банкны харилцах дансны үлдэгдэл 2.6 сая төгрөг, ХААН банкны үлдэгдэл 2.7 сая төгрөг байна.

Харилцах дансны орлого, зарлагын ажил гүйлгээ, үлдэгдлийг хураангуйлан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 2. Харилцах дансны өөрчлөлт, үлдэгдэл /сая төгрөг/

Банкны нэр	Дансны код	2021.1.01	Орлого	Зарлага	2021.12.31
ХХБ	1101-0000	305.1	8,135.8	7,914.0	526.9
Голомт	1101-0100	13.5	2,742.9	2,700.0	56.4
ХААН	1101-0200	30.2	3.5	33.3	0.4
ХААН	1101-0201	6.3	1,085.9	1,090.0	2.2
ХААН	1101-0202	3.2	1.7	4.9	0.0
Төрийн	1101-0400	27.0	11,529.6	11,085.6	471.0
Капитрон	1101-0500	3.2	94.1	94.7	2.6
НИЙТ		388.7	23,593.5	22,922.5	1,059.7

Шалгагдагч байгууллагын мөнгөн хөрөнгөд хязгаарласан болон тусгай зориулалттай, дампуурсан болон төлбөрийн чадваргүй болсон арилжааны банканд байршуулсан мөнгөн хөрөнгө байхгүй бөгөөд түүнчлэн тус компани нь мөнгөтэй адилтгах хөрөнгө эзэмшээгүй байна.

Харилцах данс бүрээс зарлагын гүйлгээ гаргаж байгаа, зарим газрын төлбөрийг шилжүүлэхдээ 2 хувааж 2 банкнаас гаргасан байгаа зэрэг нь хяналт тавих, бүртгэл хөтлөхөд бэрхшээлтэй байхаар байгааг анхаарч харилцахын зарлагын гүйлгээг төрөлжүүлэх талаар анхаарах шаардлагатай байна.

Тайлант онд тус компани нь үндсэн үйл ажиллагаатай холбоотой бараа борлуулалт, үйлчилгээ хүргэлтээс 21,903.5 сая төгрөгийн, татаас, санхүүжилтээс 300.0 сая төгрөгийн, бусад үйл ажиллагаанаас 121.5 сая төгрөгийн мөнгөн орлого олж, үүнээс ажиллагсад 3,301.6 сая төгрөг, нийгмийн даатгалын байгууллагад 964.2 сая төгрөг, ашиглалттай холбоотой зардалд 1,128.0 сая төгрөг, түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд 362.9 сая төгрөг, хүүгийн зардалд 96.0 сая төгрөг, татварын байгууллагад 842.7 сая төгрөг, даатгалд 2.2 сая төгрөг, бусад үйл ажиллагаанд 14,807.8 сая төгрөг, үндсэн хөрөнгө олж эзэмшихэд 148.5 сая төгрөг тус зарцуулсан нь өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 671.0 сая төгрөг буюу 172.6%-аар өсгөхөд нөлөөлсөн байна.

Компанийн хувьд мөнгөн хөрөнгийн үр ашгийн шинжилгээний үзүүлэлтүүдийг тооцож үзэхэд мөнгөн хөрөнгийн хувийн жин 1.7%, төлбөр барагдуулах өнөөгийн боломж 8.1%, мөнгөн хөрөнгийн хүртээмжийн коэффициент 0.03, мөнгөн хөрөнгийн хөрвөх чадварын коэффициент 1.03, мөнгөн хөрөнгийн үр ашгийн коэффициент 3.1%, мөнгөн хөрөнгийн илүүдэл 1,724.5 сая төгрөг, мөнгөн хөрөнгийн эргэлт 18.9 байна. Эдгээр үзүүлэлтээс харахад мөнгөн хөрөнгийн үр ашгийн үзүүлэлт дунд зэрэг түвшинд байна. Өөрөөр хэлбэл, мөнгөн хөрөнгийн эргэц харьцангуй хурдан, үүссэн өр төлбөрийг барагдуулахад өнөөгийн мөнгөн хөрөнгийн хүрэлцээ 1,724.5 сая төгрөгийн илүүдэлтэй байгаа зэрэг эерэг үзүүлэлтүүд байгаа хэдий ч мөнгөн хөрөнгийн хүртээмж муу, мөнгөн хөрөнгөөрөө богино хугацаанд яаралтай байгаа өр төлбөрөө барагдуулах чадвар 8.1%, 1 төгрөг тутмын мөнгөн зарцуулалтаас 0.031 мөнгөн төгрөгийн өгөөж бий болгож зэрэг сөрөг үзүүлэлтүүд байна.

Иймээс цаашид мөнгөн хөрөнгийн менежментийг сайжруулахад чиглэсэн бодлогуудыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна.

Тус компанийн авлагын данс нь 15,126.3 сая төгрөгийн дансны авлага, 570.3 сая төгрөгийн урьдчилж тооцсон тооцооны авлага, 2.5 сая төгрөгийн ажилтан албан хаагчдаас авах авлага, 5.2 сая төгрөгийн НДШ, татвартай холбоотой авлагуудаас бүрдэж байна.

Дансны авлагаас 11,583.6 сая төгрөгийн авлага нь хугацаа хэтэрсэн, 3,542.7 сая төгрөгийн авлага нь төлөгдөх хугацаандаа байгаа авлагууд байгаа бөгөөд өмнөх оноос хугацаа хэтэрсэн авлага 25.7%-аар буюу 2,366.1 сая төгрөгөөр, төлөгдөх хугацаандаа байгаа авлага 2,611.0 сая төгрөгөөр буюу 280.2%-аар өссөн нь дансны авлагыг өмнөх оноос 4,977.1 сая төгрөгөөр буюу 49%-аар өсгөхөд хүргэжээ.

Харин компанийн айл өрх, аж ахуйн нэгжүүдтэй холбоотой борлуулалттай холбоотой авлагын оны эцэс дэх үлдэгдэл 375.2 сая төгрөг байна. Үүнээс, айл өрхөөс авах авлага 222.6 сая төгрөг, аж ахуйн нэгж байгууллагаас авах авлага 152.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд борлуулалттай холбоотой авлагын үлдэгдэл өмнөх оноос 399.9 сая төгрөгөөр буюу 51.6%-аар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс айл өрхүүдээс авах авлага 170.7 сая төгрөгөөр буюу 43.4%-аар, аж ахуйн нэгжүүдээс авах авлага 229.2 сая төгрөгөөр буюу 60%-аар буурсан байгаа нь борлуулалттай холбоотой авлага цуглуулалтын менежментийн оновчтой бодлогыг хэрэгжүүлсэн гэж үзэж болно.

Компани нь найдваргүй авлагыг бүртгэх шууд аргыг ашигладаг бөгөөд тайлант онд найдваргүй гэж үзэн данснаас хассан авлага байхгүй байна.

Дансны авлагатай холбоотой дансны ажил гүйлгээ, үлдэгдлийг дараах хүснэгтээр тодруулж харуулав.

Хүснэгт 3. Дансны авлагын өөрчлөлт, үлдэгдэл /сая төгрөг/

Төрөл	Хэрэглэгч	2021.01.01	Орлого	Зарлага	2021.12.31	Зөрүү	Хувь	Бүтэц %
Дулаан	Айл өрх	145.5	4,181.9	4,255.5	71.9	(73.6)	-50.6	0.48
	ААНБ	137.7	2,600.1	2,665.3	72.5	(65.2)	-47.4	0.48
Цахилгаан	Айл өрх	106.2	2,993.5	3,030.1	69.5	(36.6)	-34.5	0.46
	ААНБ	154.7	3,518.4	3,649.0	24.1	(130.6)	-84.4	0.16
Эрчим хүч	ААНБ	261.3	772.9	698.7	335.5	74.2	28.4	2.22
Халуун ус	Айл өрх	27.8	925.9	946.2	7.4	(20.3)	-73.3	0.05
	ААНБ	12.8	363.3	373.2	2.9	(9.9)	-77.4	0.02
Цэвэр ус	Айл өрх	40.8	2,165.3	2,196.5	9.6	(31.2)	-76.5	0.06
	ААНБ	38.7	1,868.1	1,884.7	22.1	(16.6)	-42.9	0.15
Өөрийн эх үүсвэрт ус	Усан сан	19.5	296.0	313.9	1.6	(17.9)	-91.7	0.01
	Айл өрх	13.0	126.1	132.3	6.9	(6.2)	-47.2	0.05
Ариутгах татуурга	ААНБ	7.6	211.7	213.4	5.9	(1.7)	-22.5	0.04
	Айл өрх	37.4	1,452.5	1,483.2	6.8	(30.6)	-81.8	0.05
Бохир зөөвөрлөх	ААНБ	27.2	1,382.0	1,391.2	18.0	(9.2)	-34.0	0.12
	Айл өрх	0.7	9.2	9.2	0.8	0.1	12.8	0.00
СӨХ	Айл өрх	-	857.3	857.3	-	-	0.0	0.00
	ААНБ	-	0.9	0.9	-	-	0.0	0.00
Бусад	Айл өрх	0.8	4.7	4.7	0.8	0.1	6.7	0.01
	ААНБ	2.2	22.6	19.7	5.1	2.9	135.7	0.03
Бусад оршин суугч	Айл өрх	-	99.6	99.6	-	-	0.0	0.00
Бусад байгууллага	ААНБ	63.2	7,687.0	4,771.6	2,978.6	2,915.4	4,616.0	19.69
Хог тээвэр	Айл өрх	12.2	3.9	6.9	9.2	(3.0)	-24.7	0.06
Лифт	Айл өрх	4.1	127.2	113.8	17.5	13.4	326.2	0.12
Радио	Айл өрх	1.0	1.5	1.9	0.6	(0.4)	-41.3	0.00
Төлбөрт үйлчилгээ	Айл өрх	5.6	100.0	80.6	25.0	19.3	344.7	0.17
Тоолуур	ААНБ	42.7	62.6	62.0	43.2	0.5	1.3	0.29
Усны алдагдал	ААНБ	8,986.8	2,416.1	11.9	11,391.1	2,404.3	26.8	75.31
	НИЙТ	10,149.2	34,250.1	29,273.0	15,126.3	4,977.1	49.0	100.00

Дээрх хүснэгтээс харахад тус компанийн үндсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ болох дулаан, цахилгаан, ус, ариутгах татуурга зэрэгтэй холбоотой авлагууд өмнөх оноос буурсан бөгөөд тэдгээрийн нийт авлагын дүнд эзлэх багтаамж буурсан байна. Харин нийт

авлагад усны алдагдалтай холбоотой авлага 75.3% буюу хамгийн их хувийг эзэлж байгаа бөгөөд тайлант онд 2,404.3 сая төгрөгөөр буюу 26.8%-аар өмнөх оноос өссөн байна. Мөн аж ахуйн нэгж байгууллагаас авах бусад дансны авлага 2,915.4 сая төгрөгөөр буюу 4,616%-аар нэмэгдсэн нь нийт авлагын үлдэгдлийн 19.7%-ийг эзэлж байна. ААНБ-уудад түгээсэн эрчим хүч, бохирын зөөвөр, тоолууртай холбоотой болон бусад авлага, оршин суугч, айл өрхөөс авах төлбөрт үйлчилгээ, лифтний үйлчилгээтэй холбоотой болон бусад авлагууд өмнөх оноос өссөн байна.

Компанийн хувьд борлуулалттай холбоотой авлага цуглуулалт сайжирч үр дүнгээ өгч байгаа ч нийт дансны авлагын эргэц өмнөх он (эргэц 190 хоног байсан)-оос 33 хоногоор удааширч 223 хоног болсон байна. Үүнд усны алдагдлаас үүссэн авлага, бусад байгууллагатай холбоотой авлага өссөн нь их нөлөөлжээ.

Авлагын эргэц удааширч, авлагын үлдэгдэл ихсэж байгаа нь компанийн төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж, санхүүгийн тогтвортой байдал муудах сөрөг үр нөлөөг бий болгох тул авлагын удирдлагын оновчтой бодлого хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй юм.

Татвар, НДШ-тэй холбоотой авлага өмнөх оноос 10.6 сая төгрөгөөр буюу 67.2%-аар буурч 5.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй илэрхийлэгджээ. Үүнд ААНОАТ-ын авлага 2.0 сая төгрөг, НДШ-ийн авлага 0.9 сая төгрөг, ХХОАТ-тай холбоотой авлага 2.3 сая төгрөг байна. Өмнөх оноос ААНОАТ-ын авлага 0.2 сая төгрөгөөр буюу 10.8%-аар, НДШ-ийн авлага 3.8 сая төгрөгөөр буюу 81.6%-аар, ХХОАТ-тай холбоотой авлага 6.5 сая төгрөгөөр буюу 73.5%-аар тус тус буурсан нь уг бүлэг авлагыг буурахад нөлөөлсөн байна. Мөн өөрчлөлтөд тайлант оны 0.9 сая төгрөгийн ХХОАТ-ын, 64.6 сая төгрөгийн НДШ-ын ногдуулалтаар эдгээр бүлэг авлагууд өсөж, 0.2 сая төгрөгийн ААНОАТ-ын, 7.4 сая төгрөгийн ХХОАТ-ын, 68.4 сая төгрөгийн НДШ-ийн авлагын төлөлтөөр буурсан нь нөлөөлжээ.

Тайлант онд ажиллагсад, бусад хувь хүмүүстэй холбоотой авлага 1.8 сая төгрөгөөр буюу 42.5%-аар буурч 2.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Компани уг авлагыг бусад авлага дансанд хуримтлуулан бүртгэсэн байна.

Тайлант онд бараа, ажил, үйлчилгээ хүлээн авахтай холбоотой үүссэн урьдчилж төлсөн худалдан авалттай холбоотой авлага 570.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй илэрхийлэгдсэн нь өмнөх оноос 1,406.0 сая төгрөгөөр буюу 71.1%-аар буурч 570.3 сая төгрөгөөр тайлагнагдсан байна. Компани уг хөрөнгийг бусад санхүүгийн хөрөнгө дансанд хуримтлуулан бүртгэжээ. Уг авлага нь хэрэглэгчийн хэрэглээг урьдчилан тасалбар болгон бичилт хийгддэгтэй холбоотой үүсдэг байна.

Тус компани нь бараа материалаа үндсэн сэлбэг хэрэгсэл, багаж хэрэгсэл, хангамжийн материал, шатахуун ба шатах тослох материал, тээврийн хэрэгслийн сэлбэг хэрэгсэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны материал, бусад материал гэсэн ангиллаар хуримтлуулан бүртгэдэг. Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 666.9 сая төгрөг болж, өмнөх оноос 68.5 сая төгрөгөөр буюу 11.4%-аар өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын өөрчлөлт, үлдэгдэл /сая төгрөг/

Бараа материал	2021.01.01	Орлого	Зарлага	2021.12.31	Зөрүү	Хувь	Бүтэц %
Үндсэн сэлбэг хэрэгсэл	225.7	272.6	283.4	214.9	(10.8)	-4.8	32.2
Багаж хэрэгсэл	11.8	68.5	72.8	7.5	(4.3)	-36.1	1.1
Хангамжийн материал	283.9	713.1	612.3	384.6	100.8	35.5	57.7
Шатахуун, шатах тослох материал	30.6	131.3	154.2	7.6	(23.0)	-75.0	1.1
Тээврийн хэрэгслийн сэлбэг хэрэгсэл	18.0	50.7	52.9	15.8	(2.2)	-12.0	2.4
Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны материал	10.6	118.0	118.5	10.1	(0.5)	-4.9	1.5
Бусад бараа материал	18.0	37.0	28.5	26.4	8.4	46.8	4.0
Дүн	598.5	1,391.2	1,322.7	666.9	68.5	11.4	100.0

Тайлант онд худалдан авалтаар 1,150.1 сая төгрөгийн бараа материал, үнэ төлбөргүй (шатахууны урамшуулал) болон хөрөнгө оруулалтаар 241.1 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авсан байна.

Нийт бараа материалаарх хөрөнгийн 32.2%-ийг үндсэн сэлбэг хэрэгсэл, 57.7%-ийг хангамжийн материал үлдсэнийг нь бусад бараа материал эзэлж байна. Тайланд онд хангамжийн материал 100.8 сая төгрөгөөр буюу 35.5%-аар, бусад бараа материал 8.4 сая төгрөгөөр буюу 46.8%-аар өмнөх оноос өссөн бол үндсэн сэлбэг 10.8 сая төгрөгөөр буюу 4.8%-аар, багаж хэрэгсэл 4.3 сая төгрөгөөр буюу 36.1%-аар, шатахуун, шатах тослох материал 23.0 сая төгрөгөөр буюу 75%-аар, сэлбэг хэрэгсэл 2.2 сая төгрөгөөр буюу 12%-аар, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, материал 0.5 сая төгрөгөөр буюу 4.9%-аар тус тус буурсан нь бараа материалын өсөлтөд нөлөөлсөн байна.

Бараа материалын эргэц өмнөх он (өмнөх онд 19 хоног байсан)-оос 1 хоногоор түргэсэж 18 хоног болсон байна. Түүнчлэн бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй 163.5 сая төгрөгийн 334 нэр төрлийн бараа материал байна. Энэ нь ашиглагдах боломжгүй боловч данснаас хасах, актлах процесс үе шаттай явагддагтай холбоотой байна.

Эргэлтийн бус хөрөнгө өмнөх оноос 4.8%-аар буюу 2,151.0 сая төгрөгөөр өсөж, 46,521.7 сая төгрөг болсон байна.

Тайлант онд 485.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авалтаар, 2,001.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг улсын төсвийн, 2,039.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, 354.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авснаар үндсэн хөрөнгө нэмэгдэж, 1,082.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Орхон аймгийн Засаг даргын холбогдох захирамжид үндэслэн данснаас хасаж акталсан байна.

Хүснэгт 5. Эргэлтийн бус хөрөнгийн түүхэн өртөгт гарсан өөрчлөлт, бүтэц /сая төгрөг/

Үзүүлэлт	Анхны өртөг			Өөрчлөлт			Хувийн жин
	2021.01.01	Орлого	Зарлага	2021.12.31	Зөрүү	Хувь	
Барилга	8,782.0	223.7	3.6	9,002.2	220.1	2.5	11.0
Байгууламж	41,100.5	3,088.9	727.3	43,462.0	2,361.6	5.7	53.0
Машин тоног төхөөрөмж	13,802.7	918.6	257.8	14,463.5	660.8	4.8	17.6
Конторын тоног төхөөрөмж	285.8	11.3	16.1	281.0	(4.7)	-1.7	0.3
Тээврийн хэрэгсэл	1,638.6	46.7	-	1,685.3	46.7	2.9	2.1
Тавилга эд хогшил	169.2	5.0	6.0	168.2	(1.0)	-0.6	0.2
Нийтийн эзэмшил	9,738.4	586.5	63.8	10,261.1	522.7	5.4	12.5
Газар эзэмших эрх	2,465.4	-	-	2,465.4	-	0.0	3.0
Программ хангамж	229.6	-	8.3	221.4	(8.3)	-3.6	0.3
Дүн	78,212.1	4,880.8	1,082.8	82,010.1	3,797.9	4.9	100.0%

Эргэлтийн бус хөрөнгийн анхны өртөг өмнөх оноос 3,797.9 сая төгрөгөөр буюу 4.9%-аар өссөн байна. Үүнд, барилга 220.1 сая төгрөгөөр, байгууламж 2,361.6 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 660.8 сая төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 46.7 сая төгрөгөөр, нийтийн эзэмшлийн хөрөнгө 522.7 сая төгрөгөөр нэмэгдэж, конторын тоног төхөөрөмж 4.7 сая төгрөгөөр, тавилга, эд хогшил 1.0 сая төгрөгөөр буурч, газар эзэмших эрхэд өөрчлөлт гараагүй байна.

Эргэлтийн бус хөрөнгийн анхны өртгийн 76.5%-ийг барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгө, 17.9%-ийг тоног төхөөрөмж, 2.1%-ийг тээврийн хэрэгсэл, 0.2%-ийг тавилга эд хогшил, 3.3%-ийг биет бус хөрөнгө эзэлж байна. Эргэлтийн бус хөрөнгийн шинэчлэлтийн коэффициент 0.06, үндсэн хөрөнгийн хасагдалтын коэффициент 0.01 байна.

Тайлант онд байгууллагын захирлын А/37, А/77, А/115 дугаар тушаалаар 26.7 сая төгрөгийн өөрийн хөрөнгөөр 6 ус түгээх байр, 4 харуулын байр, 6 дулаан дамжуулах төвүүд, 1 цахилгааны дэд станцын барилга, конторын барилга зэрэгт засварын ажил хийж

“Барилга” дансанд капиталжуулсан байна. Мөн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 197.0 сая төгрөгөөр 6 ус түгээх байр, 1 гүний худгийг хүлээн авсан байна.

Байгууллагын захирлын А/90, А/116 дугаар тушаалд үндэслэн 163.9 сая төгрөгийн байгууламжийг өөрийн хөрөнгөөр худалдан авалт, засварын зардлын капиталжуулалт хийсэн байна. Засаг даргын А/443 дугаар захирамжаар 330.1 сая төгрөгийн байгууламжийг балансаас баланст шилжүүлэн хүлээн авсан бол улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2,592.0 сая төгрөгийн байгууламжийг хүлээн авсан байна.

Байгууллагын захирлын А/11, 115, 20, 77, 116 дугаар тушаалаар 276.6 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг өөрийн хөрөнгөөр худалдан авч орлого болгосон, мөн 620.8 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, 21.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг Засаг даргын А/165 дугаар захирамжийн дагуу балансаас баланст хүлээн авсан байна.

Тайлант онд 11.3 сая төгрөгийн конторын тоног төхөөрөмжийг байгууллагын захирлын А/37, 53, 77, 100 дугаар тушаалаар өөрийн хөрөнгөөр худалдан авсан байна. Энэ нь нийтэд үйлчилдэг үйлчилгээний ажилчдадаа зайлшгүй шаардлагаар авсан хөрөнгө байна.

Тээврийн хэрэгсэлд захирлын А/20, А/37 дугаар тушаалаар 1.8 сая төгрөгийн засвар, сайжруулалт хийж капиталжуулсан бол улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 44.9 сая төгрөгийн 2 төрлийн тээврийн хэрэгслийг хүлээн авчээ.

2021 онд 5.0 сая төгрөгийн тавилга эд хогшлыг өөрийн хөрөнгөөр худалдан авч байгууллагын захирлын А/20, А/100 дугаар тушаалаар орлого болгожээ.

Хотын гэрэлтүүлэгтэй холбоотой нийтийн эзэмшлийн хөрөнгийг 586.5 сая төгрөгийн улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хүлээн авч орлого болгожээ.

Тайлант онд Орхон аймгийн Засаг даргын А/165, А/443 дугаар захирамжаар 3.5 сая төгрөгийн барилга, 727.3 сая төгрөгийн байгууламж, 257.8 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 16.1 сая төгрөгийн конторын тоног төхөөрөмж, 6.0 сая төгрөгийн тавилга эд хогшил, 8.3 сая төгрөгийн программ хангамж, 63.8 сая төгрөгийн нийтийн эзэмшлийн хөрөнгийг данснаас хасаж акталсан байна.

Дээрх хөрөнгүүдийн хуримтлагдсан элэгдлийн үзүүлэлтүүдийг доорх хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 6. Эргэлтийн бус хөрөнгийн хуримтлагдсан элэгдэлд гарсан өөрчлөлт, бүтэц /сая төгрөг/

Үзүүлэлт	Хуримтлагдсан элэгдэл			Өөрчлөлт		Хувийн жин	
	2021.01.01	Нэмэгдсэн	Хорогдсон	2021.12.31	Зөрүү		
Барилга	717.6	262.1	2.3	977.5	259.9	36.2	2.8
Байгууламж	21,800.0	781.4	727.3	21,854.1	54.1	0.2	61.6
Машин тоног төхөөрөмж	5,457.6	625.0	257.8	5,824.8	367.2	6.7	16.4
Конторын тоног төхөөрөмж	201.3	27.3	16.1	212.5	11.2	5.6	0.6
Тээврийн хэрэгсэл	1,155.6	76.6	-	1,232.2	76.6	6.6	3.5
Тавилга эд хогшил	100.9	13.3	6.0	108.3	7.4	7.3	0.3
Нийтийн эзэмшил	4,336.2	921.8	63.8	5,194.1	857.9	19.8	14.6
Газар	-	-	-	-	-	-	0.0
Программ хангамж	72.3	20.9	8.3	84.9	12.6	17.5	0.2
Дүн	33,841.5	2,728.5	1,081.5	35,488.4	1,646.9	4.9	100.0

Эргэлтийн бус хөрөнгийн элэгдэл тайлант онд 1,646.9 сая төгрөгөөр буюу 4.9%-аар нэмэгджээ. Нийт хуримтлагдсан элэгдлийн 79%-ийг барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийн, 17%-ийг тоног төхөөрөмжийн, 3.5%-ийг тээврийн хэрэгслийн, 0.3%-ийг тавилга эд хогшлын, 0.2%-ийг биет бус хөрөнгийн элэгдэл эзэлж байна. Тайлант онд барилгын элэгдэл 259.9 сая төгрөгөөр, байгууламжийн элэгдэл 54.1 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмжийн элэгдэл 367.2 сая төгрөгөөр, конторын тоног төхөөрөмжийн элэгдэл 11.2 сая төгрөгөөр, тээврийн хэрэгслийн элэгдэл 76.6 сая төгрөгөөр, тавилга эд хогшлын

элэгдэл 7.4 сая төгрөгөөр, нийтийн эзэмшлийн хөрөнгийн элэгдэл 857.9 сая төгрөгөөр, программ хангамжийн элэгдэл 12.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Харин акталсан хөрөнгөтэй холбоотой 1,081.5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл данснаас хасагдсан байна. Эргэлтийн бус хөрөнгийн элэгдлийн коэффициент 43.3% байна.

Хүснэгт 6, 7-д тусгагдсан хөрөнгийн худалдан авалт, данснаас хасалт, байгуулсан элэгдэл зэргийн үр нөлөөгөөр эргэлтийн бус хөрөнгийн дансны үнэ дараах байдалтай болсон байна.

Хүснэгт 7. Эргэлтийн бус хөрөнгийн дансны үнийн өөрчлөлт, бүтэц /сая төгрөг/

Үзүүлэлт	Дансны үнэ		Өөрчлөлт		Хувийн жин
	2021.01.01	Зөрүү	Зөрүү	Хувь	
Барилга	8,064.4	8,024.7	(39.7)	-0.5	17.2
Байгууламж	19,300.4	21,607.9	2,307.5	12.0	46.4
Машин тоног төхөөрөмж	8,345.1	8,638.7	293.6	3.5	18.6
Конторын тоног төхөөрөмж	84.5	68.6	(15.9)	-18.9	0.1
Тээврийн хэрэгсэл	483.0	453.1	(29.9)	-6.2	1.0
Тавилга эд хогшил	68.3	59.9	(8.4)	-12.3	0.1
Нийтийн эзэмшил	5,402.3	5,067.1	(335.2)	-6.2	10.9
Газар	2,465.4	2,465.4	-	-	5.3
Программ хангамж	157.3	136.4	(20.9)	-13.3	0.3
Дүн	44,370.7	46,521.7	2,151.0	4.8	100.0

Тайлант онд барилгын дансны үнэ 39.7 сая төгрөгөөр, конторын тоног төхөөрөмж 15.9 сая төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 29.9 сая төгрөгөөр, тавилга эд хогшил 8.4 сая төгрөгөөр, нийтийн эзэмшлийн хөрөнгө 335.2 сая төгрөгөөр, программ хангамж 20.9 сая төгрөгөөр буурч, байгууламжийн дансны үнэ 2,307.5 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 293.6 сая төгрөгөөр өссөн нь эргэлтийн бус хөрөнгийн дансны үнийг 4.8%-аар буюу 2,151.0 сая төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна.

Цэвэр дүнгээр эргэлтийн бус хөрөнгийн 74.6%-ийг барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгө, 18.7%-ийг тоног төхөөрөмж, 1%-ийг тээврийн хэрэгсэл, 0.1%-ийг тавилга эд хогшил, 5.6%-ийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Эргэлтийн бус хөрөнгийн ашигт ажиллагаа 0.0025%, ачаалал 44.5%, фонд өгөмж 25.3%, фонд зэвсэглэмж 249.3 сая төгрөг байна. Энэ нь эргэлтийн бус хөрөнгийн ачаалал 44.5% байгаа нь 1 төгрөгийн үндсэн хөрөнгөөр 44 мөнгөний орлого олсныг харуулж байна. Харин ашигт ажиллагаа 0.0025% гарсан нь эргэлтийн бус хөрөнгийн 1 төгрөг тутамд 0.25 мөнгөний ашигтай ажилласан бөгөөд тухайн байгууллагын эргэлтийн бус хөрөнгийн ашигт ажиллагаа маш бага байгааг харуулж байна. Тус хөрөнгийн ашигт ажиллагаа бага байгаа нь борлуулсан бүтээгдэхүүний өртөг болон ерөнхий удирдлагын зардал өндөр байгаатай холбоотой юм. Фонд өгөмж 25.3% байгаа нь нэг төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөөр 25.3 мөнгөн орлого олох үйлчилгээ үзүүлж байна. Тайлант оны дүнгээр 1 ажилтанд 249.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө ноогдож үйл ажиллагаа явуулахдаа ашиглаж байна.

Цаашид 1 төгрөг тутмын ашгийн нэмэгдүүлэх зорилт тавьж, жил бүр балансын шинжилгээ хийж түүндээ үндэслэн бизнес төлөвлөгөөг, ашигтай байхаар төлөвлөж батлуулж байх шаардлагатай байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд дансны өглөг 12,596.5 сая төгрөг, татварын өр 59.5 сая төгрөг, урьдчилж орсон орлого 432.7 сая төгрөг, бусад богино хугацаат 38.8 сая төгрөгийн өр төлбөр байна. Тайлант онд богино хугацаат өр төлбөр 26.3%-аар буюу 2,730.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Харин урт хугацаат өр төлбөр 6.2%-аар буюу 335.2 сая төгрөгөөр буурчээ. Тайлант онд өр төлбөр 58,660.6 сая төгрөгөөр нэмэгдэж, үүнээс 56,265.1 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан байна.

Өр төлбөрийн өөрчлөлт, үлдэгдлийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 8. Өр төлбөрийн өөрчлөлт, бүтэц /сая төгрөг/

Өр төлбөр	2021.01.01	Ажил гүйлгээ		2021.12.31	Өөрчлөлт		Бүтэц %-аар
		Нэмэгдсэн	Хорогдсон		Зөрүү	Хувь	
Суугчдад өгөх өглөг	10.2	84.7	86.3	8.6	(1.6)	-15.9	0.05
Гэрээт байгууллагад өгөх өглөг	733.5	62.2	108.3	687.4	(46.1)	-6.3	3.78
Гэрээт байгууллагад өгөх өглөг (Дулаан)	-	6,076.4	6,076.4	-	-	0.0	0.00
Гэрээт байгууллагад өгөх өглөг (Хэрэглээний халуун ус)	-	878.6	878.6	-	-	0.0	0.00
Гэрээт байгууллагад өгөх өглөг (Цэвэр ус)	-	3,454.7	3,454.7	-	-	0.0	0.00
Гэрээт байгууллагад өгөх өглөг (Бусад)	-	22.3	22.3	-	-	0.0	0.00
Гэрээт байгууллагад өгөх өглөг (Хог тээвэр)	13.2	6.2	16.7	2.7	(10.5)	-79.5	0.01
Гэрээт байгууллагад өгөх өглөг (Хог тээвэр, гүйцэтгэл)	-	11.5	6.4	5.2	5.2	0.0	0.03
Гэрээт байгууллагад өгөх өглөг (СӨХ)	103.0	1,628.2	1,668.6	62.7	(40.4)	-39.2	0.34
Гэрээт байгууллагад өгөх өглөг (Радио)	1.3	1.6	2.8	0.1	(1.2)	-95.9	0.00
Гэрээт байгууллагад өгөх өглөг (Цахилгаан)	-	10,538.5	10,486.2	52.3	52.3	0.0	0.29
Бусад байгууллагуудад өгөх өглөг	233.4	21,056.2	20,932.4	357.1	123.8	53.0	1.96
Бусад байгууллагад өгөх өглөг (усны алдагдал)	8,723.3	2,914.3	288.2	11,349.4	2,626.1	30.1	62.38
Суугчдаас урьдчилж тооцсон орлого	0.0	-	0.0	-	(0.0)	-100.0	0.00
Цэвэр усны тооцоо	36.6	374.2	350.0	60.9	24.3	66.3	0.33
Урьдчилж тооцсон борлуулалтын орлого	487.2	3,283.1	3,337.6	432.7	(54.5)	-11.2	2.38
Урьдчилж тооцсон орлого /Хө/о, техникийн нөхцөл/	14.1	110.7	114.5	10.3	(3.8)	-26.9	0.06
Олгоогүй цалин	-	4,053.3	4,053.3	-	-	0.0	0.00
Орлогын татварын өглөг	-	0.2	0.2	-	-	0.0	0.00
ОАТ-ын өглөг-Хойшлогдсон татварын хөрөнгө	-	8.7	8.7	-	-	0.0	0.00
ХАОАТ-ын өглөг	-	288.4	288.4	-	-	0.0	0.00
Төвлөрсөн төсөв	4.3	2,085.9	2,030.7	59.5	55.2	1281.3	0.33
ҮЭ-ийн татварын өглөг	-	29.1	29.1	-	-	0.0	0.00
НДШ-ийн өглөг	-	1,067.5	1,067.5	-	-	0.0	0.00
Ажилчин албан хаагчдад өгөх өглөг	7.4	22.9	22.4	7.9	0.5	6.6	0.04
Бусад өглөг (хувь хүнээс)	29.3	4.1	2.5	30.9	1.6	5.4	0.17
Хойшлогдсон татварын өглөг	-	10.5	10.5	-	-	0.0	0.00
Хойшлогдсон орлого	5,402.3	586.5	921.8	5,067.1	(335.2)	-6.2	27.85
Өр төлбөрийн дүн	15,799.1	58,660.6	56,265.1	18,194.6	2,395.5	15.2	100.00

Нийт өр төлбөрийн 62.38%-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас хүлээн авсан цэвэр бохир усны объёмын зөрүү буюу усны алдагдалтай холбоотой өр төлбөр эзэлж байна. Тайлант онд энэ өр төлбөр өмнөх оноос 30.1%-аар буюу 2,626.1 сая төгрөгөөр нэмэгджээ.

Орхон аймгийн гудамж, байр, замын гэрэлтүүлгийн хөрөнгийг өөрийн үндсэн үйл ажиллагаанд ашигладаггүй тул НББОУС20 “Засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэл ба Засгийн газрын тусалцааны тодруулга”-д нийцүүлэн хойшлогдсон орлогоор хүлээн зөвшөөрч, тухайн хөрөнгөд байгуулсан элэгдлийн дүнгээр хорогдуулж бүртгэж байна. Тайлант онд уг өр төлбөр өмнөх оноос 6.2%-аар буурч 5,067.1 сая төгрөг болж, нийт өр төлбөрийн 27.85%-ийг эзэлж байна.

Тус компани нь тайлант онд гэрээт байгууллагуудтай хийх дулаан, хэрэглээний халуун ус, цэвэр ус, бусад өр, суутгагчаас урьдчилж тооцсон орлого, цалин, орлогын албан татвартай холбоотой өр, ХХОАТ-ын өглөг, үйлдвэрчний эвлэлийн байгууллагад өгөх өглөг, НДШ-ийн өглөг зэрэг өр төлбөрүүдийг бүрэн барагдуулсан байна.

Тайлант онд суугчдад өглөг өглөг 1.6 сая төгрөгөөр, гэрээт байгууллагад өгөх өглөг 46.1 сая төгрөгөөр, хог тээвэртэй холбоотой өглөг 10.5 сая төгрөгөөр, СӨХ-д өгөх өглөг 40.4 сая төгрөгөөр, радио үйлчилгээтэй холбоотой өглөг 1.2 сая төгрөгөөр, урьдчилж тооцсон борлуулалтын орлого 54.5 сая төгрөгөөр, техникийн нөхцөлийн үйлчилгээтэй холбоотой бусад урьдчилж орсон орлого 3.8 сая төгрөгөөр тус тус буурч хог тээврийн гүйцэтгэлтэй холбоотой өглөг 5.2 сая төгрөгөөр, цахилгаантай холбоотой “ЦДҮС” ТӨХК-д өгөх өглөг 52.3 сая төгрөгөөр, бусад байгууллагад өгөх өглөг 123.8 сая төгрөгөөр, цэвэр усны тооцоо 24.3 сая төгрөгөөр, төсөвт төвлөрүүлэх өр 55.2 сая төгрөгөөр, ажилтан албан хаагчдад өгөх өглөг 0.5 сая төгрөгөөр, хувь хүмүүст өгөх бусад өглөг 1.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

“Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-ийн эзэмшигчийн өмч нь 5,231.6 сая төгрөгийн төрийн (орон нутгийн) өмч, 2,586.7 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл,

43,302.2 сая төгрөгийн бусад өмч, 5,362.4 сая төгрөгийн хуримтлагдсан алдагдал зэргээс бүрдэж байгаа бөгөөд өмч өмнөх оноос 9.7%-аар буюу 4,053.6 сая төгрөгөөр өсөж 45,758.1 сая төгрөг болсон байна.

Тайлант онд 2.2 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл хөрөнгө данснаас хассантай холбоотойгоор хэрэгжиж өмнөх үеийн хуримтлагдсан ашгийг нэмэгдүүлсэн байна. Үүний үр нөлөөгөөр дахин үнэлгээний нэмэгдэл 0.1%-аар буурч 2,586.7 сая төгрөг болсон байна.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажил үйлчилгээ, нийлүүлэгдсэн хөрөнгөтэй холбоотойгоор бусад өмч 4,052.1 сая төгрөгөөр буюу 10.3%-аар нэмэгджээ. Үүнд, барилга 197.0 сая төгрөг, байгууламж 2,925.0 сая төгрөг, машин тоног төхөөрөмж 642.0 сая төгрөг, тээврийн хэрэгсэл 44.9 сая төгрөг, бараа материал 243.1 сая төгрөг болно. Өмчийн бусад хэсэгт төсвийн хөрөнгө 39,255.6 сая төгрөг, төслийн өмч 2,039.2 сая төгрөг, засгийн газрын сан 2,465.4 сая төгрөг, бусад өмч 3,263.5 сая төгрөг, нэгтгэгдсэн өмчийн бусад хэсэг (3,721.5) сая төгрөг байна.

Түүнчлэн тайлант онд 1.6 сая төгрөгийн ашигтай ажиллаж, 2.2 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл хэрэгжиж, хуримтлагдсан алдагдлыг 0.1%-аар бууруулсан байна.

Компани орлогыг СТОУС15 “Үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээний орлого”-д нийцүүлэн хүлээн зөвшөөрч бүртгэхээ Нягтлан бодох бүртгэлийн орлогын тусгай бодлогодоо тодорхойлсон байна. Үүнд нийцүүлэн дараах орлогуудыг тайлант хугацаанд хүлээн зөвшөөрч бүртгэжээ. Үүнд:

- 2021 онд тус байгууллагын борлуулалтын орлого өмнөх оноос 2,729.2 сая төгрөгөөр буюу 15.2%-аар өсөж, 20,725.1 сая төгрөг болсон байна.
- Бусад орлого өмнөх оноос 67.6 сая төгрөгөөр буюу 40.7%-аар буурч 98.7 сая төгрөг, бусад ашиг 185.2 сая төгрөгөөр буюу 99.4%-аар буурч 1.1 сая төгрөг болжээ.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үндсэн үйлдвэрлэл үйлчилгээтэй холбоотой шууд зардал, үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлын хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн үнэлгээг эдийн засгийн өгөөж буурах, хөрөнгө багасах, өр төлбөр нэмэгдэх, тэдгээрийг найдвартай хэмжихүйц байвал хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал болон бусад гарз, орлогын албан татварын зардал гэж ангилсан байна.

Борлуулалтын өртөг өмнөх оноос 1,631.8 сая төгрөгөөр буюу 14.7%-аар өсөж 12,714.4 сая төгрөг, үйл ажиллагааны зардал 334.8 сая төгрөгөөр буюу 4.3%-аар өсөж 8,106.9 сая төгрөг, үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз 23,3 сая төгрөгөөр буюу 94.8,-аар буурч 1.3 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.Түүнчлэн орлогын албан татвар зардал 0.6 сая төгрөгөөр буюу 42.9%-аар буурч 0.8 сая төгрөг болжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах, цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах, цахилгаан түгээх, тоолуур, цахилгаан шатын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлуудыг хамруулсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК нь байгууллагын

үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Компанийн ТУЗ-ын 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 58 дугаар тогтоолоор “Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 20,295.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 21,011.5 сая төгрөгөөр, 715.8 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс өөрийн хөрөнгөөр хийх үндсэн хөрөнгө, их засвар, ТЗБАХ-ийн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 650.1 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

ТУЗ-ын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 52 дугаар тогтоолоор компанийн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг 1,466.3 сая төгрөгөөр баталсан ба 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн ТУЗ-ын 59 дүгээр тогтоолоор худалдан авалтын төлөвлөгөөг 1,044.1 сая төгрөг болгон өөрчлөлт оруулсан байна.

2020 оны гүйцэтгэл болон 2021 оны үйл ажиллагаатай холбоотой орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 9. Бизнес төлөвлөгөө, орлого, зардал, ашиг алдагдлын үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны				2020/2021	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт (Хувиар)	Зөрүү	Хувь
Нийт орлого	18,370.3	20,295.7	20,858.4	562.7	102.8	2,488.1	13.5
Цахилгаан	5,158.0	5,304.1	6,175.5	871.4	116.4	1,017.5	19.7
Дулаан	7,035.7	7,292.8	7,449.1	156.3	102.1	413.4	5.9
Цэвэр ус хангамж	2,841.0	3,876.1	3,504.3	(371.9)	90.4	663.2	23.3
Ариутгах татуурга	1,983.4	2,796.4	2,522.4	(273.9)	90.2	539.0	27.2
Цахилгаан шат	115.7	115.0	115.3	0.3	100.2	(0.4)	-0.4
ӨЭҮҮ хангамж	753.6	765.6	843.9	78.4	110.2	90.3	12.0
Тоолуурын хэсэг	56.9	47.7	29.2	(18.5)	61.2	(27.7)	-48.7
Бусад	426.0	98.0	218.7	120.7	223.1	(207.3)	-48.7
Нийт зардал	18,902.4	21,011.5	20,856.8	(154.7)	99.3	1,954.4	10.3
Үндсэн ба нэмэгдэл цалин	3,852.3	3,778.4	3,870.2	91.8	102.4	17.9	0.5
Ажил олгогчоос төлөх НДШ	524.4	515.3	545.8	30.5	105.9	21.5	4.1
Цахилгаан	737.9	728.4	741.2	12.8	101.8	3.4	0.5
Дулаан	20.9	20.6	20.4	(0.2)	99.2	(0.5)	-2.2
Ус	29.2	19.0	34.2	15.1	179.4	4.9	16.8
Урсгал засвар, сэлбэг	269.7	277.2	283.5	6.3	102.2	13.8	5.1
Түлш шатахуун	131.3	126.9	132.2	5.3	104.2	0.9	0.7
Албан томилолт	2.8	5.6	1.6	(4.0)	28.8	(1.2)	-41.6
Бичиг хэрэг	17.9	20.3	18.1	(2.2)	89.0	0.2	1.3
Холбоо	25.9	30.4	26.0	(4.4)	85.5	0.0	0.1
Хөдөлмөр хамгаалал	135.9	163.9	168.8	4.8	102.9	32.9	24.2
Элэгдэл	1,663.1	1,722.2	1,806.7	84.5	104.9	143.6	8.6
Зар сурталчилгаа	2.1	4.0	4.3	0.3	108.1	2.3	110.1
Нийгмийн халамж	140.5	157.4	129.5	(27.9)	82.2	(11.0)	-7.8
ТЗЭ-ийн зохицуулалтын хөлс	34.2	41.5	81.7	40.2	196.8	47.6	139.2
Татвар, даатгалын зардал	30.6	33.5	33.0	(0.6)	98.3	2.4	7.9
Гаднын үйлчилгээний хөлс	31.7	37.0	37.0	0.0	100.0	5.3	16.6
Бусад үндсэн үйл ажиллагаа	121.7	59.6	172.7	113.1	289.6	50.9	41.9
Худалдан авсан эрчим хүч	11,082.6	11,678.0	12,714.4	1,036.3	108.9	1,631.8	14.7
Үйл ажиллагааны бус зардал	47.7	25.4	35.5	10.1	139.7	(12.2)	-25.6
Орлого болоогүй усны төлбөр	-	1,566.7	-	(1,566.7)	(100.0)	-	-
Ашиг, алдагдал	(532.1)	(715.8)	1.6	717.4	(0.2)	533.7	-100.3

Тайлант онд гүйцэтгэлээр 20,858.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 20,856.8 сая төгрөгийн зардал гарган, 1.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 20,858.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 562.7 сая төгрөг буюу 2.8% хувиар давсан байна. Үүнд, цахилгааны орлого 871.4 сая төгрөгөөр, дулааны орлого 156.3 сая төгрөгөөр, цахилгаан шатны орлого 0.3 сая төгрөгөөр, өөрийн эх үүсвэртэй усан хангамжийн орлого 78.4 сая төгрөгөөр, бусад орлого 120.7 сая төгрөгөөр тус тус өсөж, цэвэр усан хангамжийн орлого 371.9 сая төгрөгөөр, ариутгах татуургын орлого 273.9 сая төгрөгөөр, тоолуурын орлого 18.5 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлжээ. Тайлант

оны орлогын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 2,448.1 сая төгрөгөөр буюу 13.5%-аар өссөн байна. Үүнд, цахилгааны орлого 1,017.5 сая төгрөгөөр, дулааны орлого 413.4 сая төгрөгөөр, цэвэр усан хангамжийн орлого 663.2 сая төгрөгөөр, ариутгах татуургын орлого 539.0 сая төгрөгөөр, өөрийн эх үүсвэртэй усан хангамжийн орлого 90.3 сая төгрөгөөр тус тус өсөж, цахилгааны шатны орлого 0.4 сая төгрөгөөр, тоолуурын орлого 27.7 сая төгрөгөөр, бусад орлого 207.3 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 20,856.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 154.7 сая төгрөг буюу 0.7%-аар хэмнэгджээ. Үүнд, үндсэн ба нэмэгдэл цалин 91.8 сая төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ 30.5 сая төгрөгөөр, цахилгаан 12.8 сая төгрөгөөр, ус 15.1 сая төгрөгөөр, урсгал засвар, сэлбэг 6.3 сая төгрөгөөр, түлш шатахуун 5.3 сая төгрөгөөр, хөдөлмөр хамгаалал 4.8 сая төгрөгөөр, элэгдэл 84.5 сая төгрөгөөр, зар сурталчилгаа 0.3 сая төгрөгөөр, ТЗЭ-ийн зохицуулалтын хөлс 40.2 сая төгрөгөөр, бусад үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардал 113.1 сая төгрөгөөр, худалдан авсан эрчим хүчний өртөг 1,036.3 сая төгрөгөөр, үйл ажиллагааны бус зардал 10.1 сая төгрөгөөр тус тус хэтэрч, дулаан 0.2 сая төгрөгөөр, албан томилолт 4.0 сая төгрөгөөр, бичиг хэрэг 2.2 сая төгрөгөөр, холбоо 4.4 сая төгрөгөөр, нийгмийн халамж 27.9 сая төгрөгөөр, татвар даатгалтай холбоотой зардал 0.6 сая төгрөгөөр, орлого болоогүй усны төлбөр 1,566.7 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн нь нөлөөлжээ. 2021 оны зардлын гүйцэтгэлийг 2020 оны гүйцэтгэлтэй харьцуулахад нийт зардал 1,954.4 сая төгрөгөөр буюу 10.3%-аар өссөн байна. Үүнд, үндсэн ба нэмэгдэл цалин 17.9 сая төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ 21.5 сая төгрөгөөр, цахилгаан 3.4 сая төгрөгөөр, ус 4.9 сая төгрөгөөр, урсгал засвар, сэлбэг 13.8 сая төгрөгөөр, түлш шатахуун 0.9 сая төгрөгөөр, бичиг хэрэг 0.2 сая төгрөгөөр, хөдөлмөр хамгаалал 32.9 сая төгрөгөөр, элэгдэл 143.6 сая төгрөгөөр, зар сурталчилгаа 2.3 сая төгрөгөөр, ТЗЭ-ийн зохицуулалтын хөлс 47.6 сая төгрөгөөр, татвар даатгал 2.4 сая төгрөгөөр, гаднын үйлчилгээний хөлс 5.3 сая төгрөгөөр, бусад үйл ажиллагааны зардал 50.9 сая төгрөгөөр, худалдан авсан эрчим хүчний өртөг 1,631.8 сая төгрөгөөр тус тус өсөж, дулаан 0.5 сая төгрөгөөр, албан томилолт 1.2 сая төгрөгөөр, нийгмийн халамж 11.0 сая төгрөгөөр, үйл ажиллагааны бус зардал 12.2 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлжээ.

Түүнчлэн зардлын өсөлтөд дараах зүйлс нөлөө үзүүлсэн байна. Үүнд:

- Цалин болон НДШ-ийн зардлын өсөлтөд 12 сард ажиллагсдын цалинг 20%-аар нэмэгдүүлсэн;
- Цахилгааны өсөлтөд хүчин чадлын үзүүлэлтийг хэрэглэгчдийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлсэн;
- Усны зардлын өсөлтөд инженерийн шугам сүлжээний байгууламжууд хуучирч эвдрэл гэмтэл, аваар их гарсан;
- Урсгал засварын зардлын өсөлтөд импортын бараа нийлүүлэлт хязгаарлагдсантай холбоотойгоор материалын үнийн өсөлт үүссэн;
- Түлш шатахууны зардлын өсөлтөд тайлант оны шатахууны үнийн өсөлт бий болсон
- Хөдөлмөр хамгааллын зардлын өсөлтөд материалын үнийн өсөлт, үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй хэрэглээ үүссэн;
- Элэгдлийн зардлын өсөлтөд хөрөнгө оруулалтаар үндсэн хөрөнгө нэмэгдсэн;
- Зар сурталчилгааны зардлын өсөлтөд төрөөс үзүүлж буй хөнгөлөлтийн мэдээллийг сурталчлах шаардлага үүссэн;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зохицуулалтын үйлчилгээний хөлсний өсөлтөд цахилгаан, дулааны зохицуулах үйлчилгээний тусгай зөвшөөрлийг сунгуулсан;
- Бусад үйл ажиллагааны зардлын өсөлтөд халаалт жигдрүүлэхтэй холбоотой хөдөлмөр хамгаалал, хоолны зардал зарцуулсан, Улаанбаатар, Дархан-Уул аймагт туршлага солилцох сургалтад хамрагдсан, Монгол улсад нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллага үүсэж хөгжсөний 90 жилийн ойд зориулж хүндэт тэмдэг

хийлгэсэн, орон нутгийн хөрөнгө оруулалтын аваарын зардлаар хийсэн засварын ажлыг гүйцэтгэхэд материал зарцуулсан;

- Худалдаж авсан эрчим хүчний өртгийн өсөлтөд хэрэглэгчийн тоо өссөн, шинээр ашиглалтад орсон орон сууц барилгын тооны өсөлт, шинэ хороолол ашиглалтад орсон зэрэг нөлөөлсөн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу өөрийн эх үүсвэрээс 485.3 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Харин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,001.5 сая төгрөгийн, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2,039.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, нийт 4,526.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын бараа, ажил, үйлчилгээ хийж гүйцэтгэгдсэн байна. Өөрийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын 95.9 сая төгрөг нь дулааны хэсэгт, 19.7 сая төгрөг нь хэрэглээний халуун усны хэсэгт, 276.1 сая төгрөг нь цахилгааны хэсэгт, 31.5 сая төгрөг нь ус хангамжийн хэсэгт, 54.0 сая төгрөг нь өөрийн эх үүсвэртэй ус хангамжийн хэсэгт, 8.1 сая төгрөг нь ариутгах татуургын хэсэгт хийгдсэн байна. Харин улсын болон орон нутгийн төсвөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын 1,333.0 сая төгрөг нь дулааны хэсэгт, 884.0 сая төгрөг нь хэрэглээний халуун усны хэсэгт, 209.0 сая төгрөг нь цахилгааны хэсэгт, 586.5 сая төгрөг нь гэрэлтүүлгийн хэсэгт, 568.2 сая төгрөг нь ус хангамжийн хэсэгт, 556.2 сая төгрөг нь өөрийн эх үүсвэртэй ус хангамжийн хэсэгт, 258.6 сая төгрөг нь ариутгах татуургын хэсэгт хийгдсэн байна

Тайлант онд цэвэр ашиг 1.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 717.4 сая төгрөгөөр илүү байгаа нь тайлант оны орлогын төлөвлөгөө 2.8%-аар давж, зардлын төлөвлөгөө 0.7%-аар хэмнэгдсэн нь нөлөөлжээ.

Тус компани нь хуримтлагдсан алдагдалтай тул ногдол ашиг зарлаж, олгоогүй байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т хамаарах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

“Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК нь тайлант онд нийт 173 мэдээллийг шилэн дансанд ил тод байршуулахаас 168 мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлж, 1,044.1 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 8 дугаар сард мэдээлэх концессын мэдээлэл, 7 болон 8 дугаар сард үнийн дүнтэй их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл зэрэг нийт 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн талаарх хугацаа нь болоогүй 1 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь хугацаа хоцроож мэдээлсэн 4

мэдээллийг эс тооцвол Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтууд нийцсэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаж байна гэж дүгнэлээ. Цаашид Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “*тогтсон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх*” гэснийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

2021 онд “Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК нь худалдан авалттай холбоотойгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.1-д “*захиалагч урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэний улмаас гэрээнд зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийхээс бусад тохиолдолд тендерийн агуулгатай холбоотой гэрээний нөхцөлүүдийг өөрчлөхийг хориглоно*” гэж заасныг зөрчиж тендерт шалгарсан этгээдийн хүсэлтээр гэрээний хугацааг сунгаж, техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулсан, 14 дүгээр зүйлийн 14.1.4-д “*сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, энэ хуулийн 52.1-д заасан эрх бүхий улсын байцаагч тогтооно*” гэж заасны дагуу гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчийн гэрээг улсын байцаагчаар цуцлуулах ёстой байсныг зөрчсөн, “*Тендер шалгаруулалтын онцгой журам*”-ын дагуу харьцуулалтын аргаар тендер зарлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4-т “*Харьцуулалт амжилтгүй болсноос гэрээ байгуулах эрх олгоогүй бол гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэж болно*” гэсэн заалт нь 2019 оны 03 дугаар сарын 22-нд хүчингүй болсон (харьцуулалт амжилтгүй болсон) байхад гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэсэн зэрэг зөрчлүүд илэрлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд шалгасан 188.1 сая төгрөгийн 4 төрлийн худалдан авалт нь хуулийн холбогдох заалтад нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Аудитын төлөвлөлтийн үеийн цаг хугацааны хязгаарлалтаас үүдэн бид завсрын аудитыг хийж гүйцэтгээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,387.9 сая төгрөгийн зөрчилд 2,246.7 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 3,141.2 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс албан шаардлага 100 хувь, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 10. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	2,246.7	2	2,246.7	0	0	
Зөвлөмж	3	3,141.2	3	3,141.2	0	0	
Нийт дүн	5	5,387.9	4	5,387.9	0	0	

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 422 тоот албан бичгээр Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бид дараагийн аудитаар тус компанийн орлогын бүрдүүлэлтэд тавигддаг дотоод хяналтын тогтолцоо, механизмд анхаарал хандуулахыг хүсэж байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 266.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 248.9 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 18.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 266.9 сая төгрөгийн материаллаг алдаа зөрчил нь тогтоосон 282.7 төгрөгийн түвшнээс даваагүй тул зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Бидний гүйцэтгэсэн аудитын горим, сорилоор илрүүлсэн алдаа, зөрчил нь 2021 оны санхүүгийн тайлагнал, толилуулгад залруулагдах боломжгүй алдаа, зөрчлүүд байна.

8.2 Төлбөрийн акт

Бидний гүйцэтгэсэн аудитын горим, сорилоор төлбөрийн акт ногдуулах алдаа, зөрчил илрээгүй болно.

8.3 Албан шаардлага

1. Төсвийн хэмнэлтийн бодлоготой холбоотой асуудал

Ажилчдын цалинг 2021 оны 12 дугаар сарын 1-ны өдрөөс 20 хувь нэмэгдүүлэн 48.3 сая төгрөг болгож олгосон, шагналд 6.0 сая төгрөг олгосон, хүндэт медаль 327 ширхгийг 6.6 сая төгрөгөөр хийлгэсэн, нийт 60.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын 1.3 “... цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, ...”, гэсэнд нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Худалдан авалттай холбоотой асуудал

Нийт 188.1 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулахдаа гэрээний нөхцөлийг өөрчилсөн, сүүлийн 3 жил гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчийн гэрээг улсын байцаагчаар цуцлуулаагүй, 2019 онд хүчингүй болсон заалтыг үндэслэн гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэсэн нь “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 41 дүгээр зүйлийн 41.1.1-д “захиалагч урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэний улмаас гэрээнд зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийхээс бусад тохиолдолд тендерийн агуулгатай холбоотой гэрээний нөхцөлүүдийг өөрчлөхийг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.1.4-д “сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, энэ хуулийн 52.1-д заасан эрх бүхий улсын байцаагч тогтооно”, 33 дугаар зүйлийн 33.4-т “Харьцуулалт амжилтгүй болсноос гэрээ байгуулах эрх олгоогүй бол гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэж болно” (жич: энэ заалт 2019 оны 03 дугаар сарын 22-нд хүчингүй болсон) гэсэн заалтуудад нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийт 18.0 сая төгрөгийн зэргийн нэмэгдэл цалин хөлсийг тооцоолж олгохдоо ажиллагсдын гүйцэтгэсэн ажлын тайланг үнэлээгүй, цаасаар болон цахимаар сургалт хийгээгүй, хийсэн ажлыг Захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэлгүй олгосон байна. Энэ нь тус компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан "Зэргийн нэмэгдэл олгох журам"-ын 4.3 дахь заалтад нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Зэргийн нэмэгдэл олгохдоо батлагдсан журмыг мөрдөж, хийсэн ажлын тайланг хэлэлцэж дүгнэж олгох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

"МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ" ХХК-ийн

АХЛАХ АУДИТОР:

АУДИТОР:

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР:



Л.БААСАНДОРЖ

Огноо:

E/S

З.БАТТУЯА

Огноо:

М.БЯМБАДОРЖ

Огноо:

Б.БАЙГАЛ

Огноо:

Б.ЭРДЭНЭ

Огноо:

Ц.НАРМАНДАХ

Огноо:



9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/										
							Үүнээс										
					Тоо	Дүн	Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Санхүүгийн тайлангийн асуудлаар																	
1	“Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК	ОРА-2022/7/НА-СТА-ОНӨААН	Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол зөрчсөн	Ажилчдын цалинг 20 хувь 48,263.8 мянган төгрөг нэмэгдүүлж олгосон, 12,588.1 мянган төгрөгөөр шагнасан, нийт 60,851.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	60,851.9							1	60,851.9			
2	“Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК	ОРА-2022/7/НА-СТА-ОНӨААН	“Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-ийн захирлын баталсан “Зэргийн нэмэгдэл олгох журам”-ыг зөрчсөн	Нийт 18,040.5 мянган төгрөгийн зэргийн нэмэгдэл цалин хөлсийг гүйцэтгэсэн ажлын тайланг үнэлээгүй, олгосон байна.	1	18,040.5									1	18,040.5	
			ДҮН		2	78,892.4							1	60,851.9		1	18,040.5
6	“Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК	ОРА-2022/7/НА-СТА-ОНӨААН	“Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийг зөрчсөн	2021 онд 188,054.9 мянган төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулахдаа гэрээний нөхцөлийг өөрчилсөн, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэчийн гэрээг улсын байцаагчаар цуцлуулаагүй, 2019 онд хүчингүй болсон заалтыг үндэслэн гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэсэн	1	188,054.9							1	188,054.9			
			ДҮН		1	188,054.9								1	188,054.9		
			НИЙТ ДҮН		3	266,947.3							1	248,906.8		1	18,040.5